



Ард Даатгал



АРД ДААТГАЛ ХК – ЖИЛИЙН ТАЙЛАН

2024

I Агуулга

1 ТУЗ-ИЙН ДАРГЫН ИЛГЭЭЛТ

2 ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

3 АРД ДААТГАЛ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанийн танилцуулга

Түүхэн замнал

Онцлох үйл явдлууд

Даатгалын үйл ажиллагаа

4 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Ердийн даатгалын салбарын өнөөгийн байдал

5 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БҮТЭЦ БОЛОН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

Хувьцааны арилжааны мэдээ

Хувьцаа эзэмшигчийн бүтэц

7 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Засаглалын бүтэц, үйл ажиллагаа

Хүний нөөц

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Төлөөлөн удирдах зөвлөл

8 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлага

Давхар даатгалын үйл ажиллагаа

Нөхөн төлбөрийн үйл ажиллагаа

Комплайнсын хөтөлбөр

9 КОМПАНИЙН 2024 ОНЫ АУДИТЛАГДСАН ТАЙЛАН



ТУЗ-ИЙН ДАРГЫН ИЛГЭЭЛТ

**НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАГЧ, ДААТГУУЛАГЧ, ХАРИЛЦАГЧ,
ХАМТРАН АЖИЛЛАГЧ ТҮНШҮҮД ТАНАА**



2024 онд Монгол улсын эдийн засгийн өсөлт тогтвортой байж 5 хувийн өсөлтийг үзүүлсэн бөгөөд үүнд уул уурхай, үйлдвэрлэл, тээвэр логистикийн салбар голлох нөлөө үзүүлсэн байна. Эдийн засгийн өсөлтийг дагаад Монгол улсын даатгалын салбарын голлох үзүүлэлтүүд 2023 оноос өсөлттэй байсныг Санхүүгийн Зохицуулах Хорооны Даатгалын салбарын нэгтгэлд дурдсан байна.

Даатгалын салбарын нэгтгэлээс харахад Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө 582.3 тэрбум төгрөгт хүрсэн нь 2023 онтой харьцуулахад 24 хувь, эздийн өмчийн дүн 225.5 тэрбум төгрөгт хүрч 24 хувь, даатгалын нийт хураамж 498.3 тэрбум төгрөгт хүрч 28 хувь, үүнийг дагаад даатгалын нөхөн төлбөр 158.3 тэрбум төгрөг болж 33 хувийн өсөлтийг үзүүлж Даатгалын салбар үүсэж хөгжсөний 90 жилийн ойгоо үджээ.

Мөн даатгалын хураамжийн орлогыг дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа буюу Даатгалын гүнзгийрэлтийн түвшин өнгөрсөн оноос 0.06 нэгжээр өсөж 0.64 хувь, нэг хүнд ноогдох даатгалын нийт хураамж буюу даатгалын нягтрал 26.5 хувиар өсөж 143.5 мянган төгрөгт хүрсэн байна.

Хэдийгээр дээрх үзүүлэлтүүд нь жилээс жилд өсөж байгаа ч дэлхийн дундажтай харьцуулахад харьцангуй бага байгаа нь даатгалын салбарт илүү орон зай, эрчтэй ажиллах, шинэчлэл хийх шаардлагатай байгааг илтгэж байна.

Ялангуяа иргэдэд даатгалын боловсрол олгох, ач холбогдлыг ойлгуулан сурталчлах, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг шинэ шатанд гаргах, цахим даатгалын үйлчилгээг сайжруулах хэрэгцээ шаардлага даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй хэн бүхний өмнө тулгарч байна.

Даатгалын салбарт төрөөс явуулж буй бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулах, албан журмын

ТУЗ-ИЙН ДАРГЫН ИЛГЭЭЛТ

даатгалын төрлийг нэмэгдүүлэх, Даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг бодлогоор дэмжсэнээр даатгалын нягтрал өсөх, иргэдийн даатгалын боловсрол нэмэгдэнэ гэж үзэж байна.

2024 онд Ард даатгал компанийн үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ой тохиосон бөгөөд Компанийн бүхий л санхүүгийн үзүүлэлтүүд өсөж, шинэ шинэ ололт амжилтуудыг бүтээж 30 жилийнхээ ойг үдлээ. Төлөөлөн удирдах зөвлөлөөс Гүйцэтгэх удирдлага болон Компанийн бүтцэд өөрчлөлт оруулж, Компанид ажиллаж байсан залуусыг залгамж халааны бодлогыг баримтлан Гүйцэтгэх удирдлагын багт томилсон нь компанийн өдөр тутмын ажлыг тогтвортой удирдан ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж өгсөн гэж үзэж байна.

Эцэст нь даатгалын салбарт Даатгуулагчийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн, мэргэжлийн ёс зүйг баримталсан, даатгалын шилдэг үйлчилгээг үзүүлэх эрхэм зорилготой Ард даатгал ХК-ийн үнэт зүйлс болсон нийт ажилтнуудад Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын хувиар талархсанаа илэрхийлье. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж байгаадаа баяртай байна.

Хүндэтгэсэн:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

О.ОДБАЯР

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

**НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧ, ДААТГУУЛАГЧ, ХАРИЛЦАГЧ,
ТҮНШҮҮД ТА БҮХНИЙ АМГАЛАНГ АЙЛТГАЯ.**



2024 онд Ард даатгал ХК даатгалын салбарт анхны хувийн даатгалын компани болон үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ой, мөн Монгол улсад даатгалын салбар үүссэний 90 жилийн ой тохиосон онцгой жил байлаа.

Даатгалын салбарын ууган компаниудын нэг болох Ард даатгал компани нь 2024 онд 257 мянга гаруй харилцагч, даатгуулагчаас нийт 45.2 тэрбум төгрөгийн хураамжийг цуглуулж, 13 мянган харилцагчид 19.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгож, даатгалын хураамж болон нөхөн төлбөрийн дүнгээр өмнөх оноос тус тус 39 хувийн өсөлтийг үзүүлжээ.

Компанийн даатгал хариуцсан ажилтнууд болон хамтран ажиллагч даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагч нар ажлын 1 өдөрт дунджаар 985 даатгалын гэрээ хийж, нөхөн төлбөр хариуцсан ажилтнууд ажлын 1 өдөрт 50 даатгуулагчид дунджаар 75 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон гэсэн судалгаа гарчээ.

Нөхөн төлбөрийн зардал төсөвлөсөн дүнгээс өндөр байсантай холбоотой компанийн цэвэр ашиг өнгөрсөн оноос 36 хувийн бууралттай байсан. **Даатгалын компанийн үндсэн зорилго бол** даатгуулагчид даатгалын гэрээнд заасан эрсдэл учрахад тэдэнд үүссэн санхүүгийн бэрхшээлийг шийдвэрлэхэд оршдог тул бид даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлсэндээ компанийн удирдлагын багийн зүгээс баяртай байна.

Бид 2024 онд Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Жолоочийн даатгалын гэрээний тоо, хураамж болон нөхөн төлбөр олголтын дүнгээр салбартаа манлайлан ажиллаа. Жолоочийн даатгалын хамрагдалтаар салбарын 22 хувь, нөхөн төлбөр олголтын дүнгээр салбартаа 21 хувийг эзэлж байна. Ташрамд бидний ажиллагааг ойлгож, хүлээцтэй хандаж ирсэн харилцагч, даатгуулагч нартаа талархаж байна. Бид цаашид ч танд учирсан санхүүгийн хохирлыг шийдвэрлэж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд анхаарч ажиллах болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ


2024 онд Даатгалын тухай хуульд өөрчлөлт орсны дагуу Даатгалын компаниуд даатгагчийн баталгаа гаргах үйлчилгээг үзүүлж эхэлсэн бөгөөд бид 146 байгууллагад 9.6 тэрбум төгрөгийн даатгагчийн баталгааг гаргаж салбартаа манлайлан ажиллаа. Мөн даатгалын салбарт анх удаа Тогтвортой хөгжлийн тайланг гарган олон нийтэд танилцуулсан анхдагч даатгалын компани болсондоо таатай байна.

Бидэнд итгэн эрсдэлээ даатгуулсан даатгуулагч нар, бидэнд хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нарт, өнгөрсөн, одоо, ирээдүйд бидэнтэй хамтран даатгалын салбарын түүхийг бичилцэж буй оролцогч талууд болон Компанийн үнэт хөрөнгө болсон нийт ажилтнууддаа талархал илэрхийлж, 2024 оны Компанийн үйл ажиллагаа болон Санхүүгийн тайланг өргөн барьж байна.

Хамтын ажиллагаанд талархсан:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.ЭРДЭНЭТУЛГА





АРД ДААТГАЛ КОМПАНИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА

АРД ДААТГАЛ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ард даатгал ХК нь 1994 онд үүсгэн байгуулагдаж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасан шаардлагуудыг ханган Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2/16 тоот даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч 30 гаруй жил үйл ажиллагаа явуулж буй Хувьцаат Компани юм.



2018 онд IPO гарган 9,500 орчим хувьцаа эзэмшигчтэй Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани болсон.

Өдгөө Монгол Улсын даатгалын салбарт тэргүүлэгч байр суурь бүхий олон улсад болон дотоодод нэр хүндтэй, тогтвортой даатгалын үйлчилгээ үзүүлэгч болсон төдийгүй баялаг бүтээгчдийн найдвартай ар тал болон дэмжиж ажилласаар ирсэн нь улсынхаа эдийн засаг, нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмрээ оруулан амжилттай ажиллаж байгааг харуулж байна.

Бидний үйл ажиллагааны зарчим нь CIRCLE буюу ХҮРД гэсэн утгатай дараах бүтэцтэй.

C I R C L E

Customer

Integrity

Responsibility

Collaboration

Long term
respective

Excellence
in service

Даатгуулагчаа цаг ямагт хүндэтгэсэн	Итгэл хүлээж, ёс зүйг баримталсан	Хариуцлагатай даатгалын үйлчилгээг санал болгосон	Эрсдэлийн удирдлагын зохистой бодлогыг хамтран боловсруулан, болзошгүй эрсдэлээс ямагт урьдчилан сэргийлдэг	Урт хугацааны түншлэлийн харилцааг эрхэмлэж, оролцогч талуудыг амжилтад хөтөлсөн	Мэргэжлийн түвшний даатгалын хамгаалалт, үйлчилгээг даатгуулагчдаа санал болгосон
-------------------------------------	-----------------------------------	---	---	--	---

■ Түүхэн замнал

1994 он

Ард даатгал ХХК үүсгэн байгуулагдаж анхны хувийн даатгалын компани болов.

2004 он

Их Британийн Omni Whittington Group хөрөнгө оруулав.

2010 он

Агаарын хөлгийн даатгалын үйлчилгээг нэвтрүүлэв.

2011 он

Оюу толгой төслийн бүтээн байгуулалтад оролцож эхлэв. Гранд даатгал ХХК-ийг өөртөө нэгтгэв.

2012 он

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйлчилгээг үзүүлж эхлэв.

2013 он

Ард санхүүгийн нэгдэл ХХК хөрөнгө оруулагч болов.

2016 он

Малын индексжүүлсэн даатгалын үйлчилгээ үзүүлж эхлэв. ХБНГУ-ын Ханновер Ри компанитай Давхар даатгалын ТРИТИ гэрээг байгуулав.



Түүхэн замнал

2017 он

MSH International-тай Олон улсын эрүүл мэндийн даатгал хэрэгжүүлж эхлэв. Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-тай хамтран Тариалангийн даатгалыг хэрэгжүүлж эхлэв.

2018 он

IPO гаргаж нээлттэй хувьцаат компани болов.

2019 он

Ард апп"-д Даатгал цэс нэмэгдэж, онлайн даатгалын үйлчилгээг нэвтрүүлэв.

2020 он

Ковид 19 цар тахлын хамгаалалт бүхий шинэ даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.

2021 он

Даатгалын үйлчилгээг бүрэн цахимжуулав.

2022 он

Харилцагчийн мэдээллийн бааз үүсгэж, CRM системийг хэрэгжүүлж эхлэв.

2023 он

Жолоочийн даатгалын борлуулалтаар салбартаа тэргүүлэгч болов.

2024 он

Салбартаа анх удаа Тогтвортой хөгжлийн тайлан гаргав. Баталгааны даатгалын үйлчилгээг нэвтрүүлэв.

Тоон үзүүлэлт

○ N°1 Хувьцаа эзэмшигчийн тоогоор	○ 21 Салбарын тоо	○ 257K Даатгуулагчийн тоо
○ +70 Хамтран ажилладаг зуучлагч	○ 45 тэрбум Хураамжийн орлого	○ 5 Хамтран ажилладаг банк
○ +30 Үйл ажиллагаа явуулсан жил	○ 19 тэрбум Олгосон нөхөн төлбөр	○ 9% Зах зээлд эзлэх хувь
○ 9.5K Хувьцаа эзэмшигч	○ +50 Даатгалын бүтээгдэхүүн	○ +100 Ажилтны тоо

Онцлох үйл явдлууд

- 2024 онд Даатгалын салбар үүсэж хөгжсөний 90 жил, Ард даатгал компанийн үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд ажилтнууд болон харилцагч нарт чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулсан.
- Даатгалын салбарт анх удаа “Тогтвортой хөгжлийн тайлан 2023” тайланг гаргаж, даатгалын зах зээлийн бусад оролцогч нарт энэхүү тайланг гаргахыг уриалсан үйл ажиллагааг зохион байгуулсан.
- Хувьцаа эзэмшигчдэдээ 750 сая төгрөг (нэгж хувьцаанд 30 төгрөг)-ийн ногдол ашиг олгосон.
- Даатгалын нөхөн төлбөрийн хүсэлт илгээх болон даатгалын гэрээ цуцлах хүсэлтийг цахимаар авч шийдвэрлэдэг болсон.
- Мессеж үйлчилгээгээр Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээг онлайнаар сунгах үйлчилгээг эхлүүлэн хэрэгжүүлж байна.
- Баталгааны даатгал, ногоон даатгалын үйлчилгээг зах зээлд шинээр нэвтрүүлсэн.
- Даатгалын салбарын 90 жил болон Ард даатгал ХК-ийн 30 жилийн ойг тохиолдуулан СЭЗИС-тай хамтран банк санхүү, бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монгол улсын бүх Их, дээд сургуулийн бакалаврын түвшний оюутнуудын дунд “ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СОРИЛТУУД БА ШИЙДЛҮҮД” сэдвийн хүрээнд Эрдэм шинжилгээний хурлыг 2 үе шаттайгаар амжилттай зохион байгуулж, шилдэг илтгэлүүдийг шалгаруулж, шагнаж урамшууллаа.

■ Даатгалын үйл ажиллагаа

Ард даатгал ХК нь ердийн даатгалын компани бөгөөд албан журмын даатгалаас гадна сайн дурын 50 гаруй төрлийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдадаа санал болгож байна. Бид жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, малын индексжүүлсэн даатгал, газар тариалангийн даатгал, баталгааны даатгалыг анхлан хэрэгжүүлэгчдийн нэг билээ.



Даатгалын багцын мэдээлэл

2024 онд даатгалын 12 хэлбэрийн 50 гаруй бүтээгдэхүүнээр нийт 40.2 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий даатгалын гэрээ хийгдсэн бөгөөд Компанийн нийт хүлээж буй хариуцлагын 45 хувийг хөрөнгийн даатгал болон хариуцлагын даатгал эзэлж байна.

Даатгалын нийт хураамжийн орлого 2023 оноос 39 хувь, даатгуулагчийн тоо 20 хувиар өссөн байна. Даатгалын багцын мэдээллийг хүснэгтлэн харуулбал:

Даатгалын хэлбэр	Нийт хураамж (сая төгрөг)			Даатгуулагчийн тоо (мянга)		
	2023 он	2024 он	өөрчлөлт	2023 он	2024 он	өөрчлөлт
ГО, эмчилгээний даатгал	5,217	5,320	2%	21.0	24.5	17%
Хөрөнгийн даатгал	5,557	6,487	17%	14.9	17.5	17%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	6,982	12,062	73%	11.1	17.1	54%
Ачааны даатгал	348	427	23%	0.2	0.2	-13%
Барилга угсралтын даатгал	552	2,303	317%	0.01	0.02	36%
Хариуцлагын даатгал	2,064	4,372	112%	0.5	0.7	45%
Жолоочийн албан журмын даатгал	7,957	11,874	49%	142.0	194.7	37%
Бусад	3,762	2,399	-36%	24.7	2.8	-89%
НИЙТ	32,438	45,244	39%	214.3	257.5	20%

АРД ДААТГАЛ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсны дагуу Даатгагчийн баталгаа гаргах боломжтой болсон.

Хуулийн өөрчлөлттэй холбоотой СЗХ-ны “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам” батлагдсан ба Ард даатгал компани нь “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ыг ТУЗ-өөр батлуулан даатгагчийн баталгаа гаргах ажлыг 2024 оны 4 сараас хэрэгжүүлж эхэлсэн.

2024 онд Ард даатгал ХК нь **тендерийн, урьдчилгаа төлбөрийн, гүйцэтгэлийн** баталгаа гаргах үйл ажиллагааг шинээр нэвтрүүлэн ажиллаа.

№	Даатгалын салбар	Ард даатгал ХК	Эзлэх %
1	Гэрээний тоо	337	43%
2	Баталгааны дүн (тэрбум₮)	22.3	43%
3	Хураамжийн дүн (тэрбум₮)	1.6	30%



/олон улсын эрүүл мэндийн даатгал/

Дэлхийн 200 гаруй оронд 330 мянга гаруй гэрээт эмнэлгүүдээр үйлчлүүлэх өргөн сүлжээ бүхий олон улсын MSH China эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагатай хамтран ажиллаж, хэрэгжүүлдэг бүтээгдэхүүн юм. Тус даатгал нь даатгуулагчдад эмнэлгийн тусламж үйлчилгээг төлбөр төлөхгүйгээр Монгол улсад төдийгүй БНХАУ, Солонгос, Япон, Ази номхон далайн орнууд болон дэлхийн улс орнууд дахь сүлжээ эмнэлгүүдээс үйлчилгээ авах боломжийг олгодог.

Хамтын ажиллагаа

Бид бизнесийн үйл ажиллагаандаа харилцан ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэж, нийгмийн бүхий л салбарт хүрч ажиллажээ.

/эрүүл мэнд гэнэтийн ослын даатгал/

Ард Мэнд даатгал нь эрүүл мэндийн даатгал болон гэнэтийн ослын даатгалыг хамтад нь хамруулсан цогц даатгалын бүтээгдэхүүн юм. Ард Мэнд даатгалын бүтээгдэхүүн нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй бүх шатлалын эмнэлгүүдээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах боломжийг олгодог. Даатгуулагчдад даатгалын өндөр үнэлгээ бүхий хамгаалалт, уян хатан нөхцөлийг санал болгодог.

+230

Төрийн
байгууллагууд

80%


МҮХАҮТ-ийн ТОП
100 ААН

ТББ

BNI Business Network International
Auscham Mongolia (Австралийн ХАҮТ)
Amcham Mongolia (Америкийн ХАҮТ)
BCM Business Council of Mongolia

Бусад

Монгол улс
дахь гадаад
улсын ЭСЯ



ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН
МЭДЭЭ

ЕРДИЙН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

2024 оны жилийн эцсийн байдлаар Даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй компани болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тоо дараах байдалтай байна.

Даатгалын компани

Ердийн даатгалын компани	17
Урт хугацааны даатгалын компани	2
Давхар даатгалын компани	1

Даатгалын мэргэжлийн оролцогч

Даатгалын зуучлагч компани	51
Даатгалын зуучлагч банк	9
Даатгалын төлөөлөгч	2,504
Даатгалын хохирол үнэлэгч	29

ЕРДИЙН ДААТГАЛЫН ТООН МЭДЭЭ

	Зах зээл	Зах зээлийн дундаж	Ард даатгал
Даатгалын нийт хураамж	498,328	31,146	45,244
Давхар даатгалын хураамж	165,337	9,726	7,150
Даатгалын цэвэр хураамж	318,292	19,893	36,800
Орлогд тооцсон хураамж	280,830	16,519	33,610
Нийт нөхөн төлбөр	158,326	9,895	19,663
Цэвэр нөхөн төлбөр	123,513	7,720	16,338
Үйл ажиллагааны зардал	168,052	9,885	16,311
Нийт хөрөнгийн дүн	582,346	34,256	51,133
Нөхөн төлбөрийн нөөц сангийн дүн	78,078	4,593	6,102
Эздийн өмчийн дүн	225,485	13,254	19,595
Хохирлын харьцаа*	56%	-	59%
Зардлын харьцаа*	60%	-	49%
Хосолсон харьцаа*	116%	-	108%

* Эх сурвалж: СЗХ-ны 2024 оны даатгалын салбарын үйл ажиллагааны нэгдсэн тайлан


ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал

"Жолоочийн даатгалын тухай хууль"-ийн хэрэгжилтийг ханган Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хамрагдалтаар салбартаа тэргүүлэн ажиллаа. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйлчилгээ үзүүлэгч 16 даатгалын компани байдаг бөгөөд 2024 оны жилийн эцсийн тайлангийн байдлыг графикаас харж болно.

ЖД-ын хураамж (сая.төг)

55,050




11,874

● Бусад 15 даатгагч ● Ард даатгал ХК




ЖД-ын нөхөн төлбөр (сая.төг)

44,140



9,365

● Бусад 15 даатгагч ● Ард даатгал ХК



Хувьцаа эзэмшигчийн бүтэц
болон хувьцааны

АРИЛЖААНЫ МЭДЭЭ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Ард даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тоо 2024 оны жилийн эцсийн байдлаар 9,506 болж оны эхнээс 257 хувьцаа эзэмшигчээр буурсан байна. Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчийн бүтцэд томоохон өөрчлөлт гараагүй байна.

Хувьцаа эзэмшигчид

56.7%

43.3%



Ард санхүүгийн
нэгдэл ХК*


Иргэд, аж ахуйн
нэгж

Хувьцааны
тоо ширхэг

25 сая

ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

2024 онд 1.3 тэрбум төгрөгийн 1.9 сая ширхэг хувьцааны арилжаа хийгдсэн бөгөөд хувьцааны дээд үнэ 840 төгрөг, доод үнэ 620 төгрөгт хүрч, жилийн арилжааны сүүлийн өдөр 800 төгрөгөөр хаагдсан байна. Компанийн үнэлгээ 2024 оны жилийн эцсээр 20.0 тэрбум төгрөг болсон байна.



Хаалтын ханш	₮800
Дээд болон доод ханш:	₮620 - ₮840
Нийт хувьцааны тоо:	25,000,000
Нийт арилжаалагдсан тоо:	1.9 сая
Нийт арилжааны дүн:	₮1.3 тэрбум
Зах зээлийн үнэлгээ:	₮20.0 тэрбум

EPS:	₮82
BVPS:	₮780
P/E – Үнэ/Ашиг:	9.76
P/B – Үнэ/Дансны үнэ:	1.03

КОМПАНИЙН
ЗАСАГЛАЛ



Засаглалын бүтэц, үйл ажиллагаа



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд зааснаар Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна. ТУЗ-ийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулдаг.

Ард даатгал ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2024 оны 4-р сарын 23-ны өдөр хийж дараах асуудлуудыг хэлэлцэж



- ✓ Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай
- ✓ Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай
- ✓ Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай
- ✓ ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-ийн гишүүдийг 2 жилийн хугацаатай сонгосон бөгөөд Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэгт “Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна” гэж заасны дагуу өнөөдрийн байдлаар 6 ердийн, 3 хараат бус гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. ТУЗ нь компанийн бүхий л шатанд ил тод, үнэнч шударга байдлыг эрхэмлэн, нээлттэй засаглалыг бий болгохын зэрэгцээ компанийн бодлогыг тодорхойлж, үйл ажиллагааг чиглүүлж, дэмжин ажилладаг.

Ард даатгал ХК-ийн эрх барих дээд байгууллага Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон 9 гишүүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийг ерөнхий удирдлагаар хангахаас гадна үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар шийдвэр гарган ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь ердийн 6, хараат бус 3 гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



О.Одбаяр

ТУЗ-ийн дарга



Г.Уянга

Ердийн гишүүн



Б.Золбоо

Ердийн гишүүн



С.Оргил

Ердийн гишүүн



Ч.Ганзориг

Ердийн гишүүн



Г.Цогбадрах

Ердийн гишүүн



З.Ариун

Хараат бус гишүүн



Т.Билгээ

Хараат бус гишүүн



Б.Болорчимэг

Хараат бус гишүүн гишүүн

“ Төлөөлөн удирдах зөвлөл нь 2024 онд эчнээгээр 2 удаа, ээлжит болон ээлжит бусаар 7 удаа хуралдаж 24 шийдвэр гаргасан бөгөөд онцлох шийдвэрүүдээс дурдвал:

- ✓ Ногдол ашиг хуваарилах тухай
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай
- ✓ 2023 оны аудитлагдсан тайланг дүгнэж ТУЗ-ийн дүгнэлт гарган батлах тухай
- ✓ Гүйцэтгэх захирлын үнэлгээ батлах тухай
- ✓ Шинэ бүтээгдэхүүн батлах тухай;
- ✓ Гүйцэтгэх захирал чөлөөлөх тухай;
- ✓ Гүйцэтгэх захирал томилох тухай;
- ✓ Компанийн 2025 оны төсөв төлөвлөгөө батлах тухай

Гүйцэтгэх удирдлагын баг

Компанийн удирдлагын баг нь даатгалын салбарт олон жил ажилласан чадварлаг удирдах ажилтнуудаас бүрддэг бөгөөд олон жилийн туршлага, хамтын шийдвэр нь удирдлагын багийн харилцан ойлголцлыг бий болгож Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг амжилттай явуулах суурь болдог.



Н.Эрдэнэтулга

Гүйцэтгэх захирал



Т.Батцэнгэл

Үйл ажиллагаа, санхүү хариуцсан захирал



Г.Баярбат

Эрсдэл, хөрөнгийн удирдлагын газрын захирал



Т.Мөнх-Оргил

Даатгалын газрын захирал



Ё.Алзахгүй

Нөхөн төлбөрийн газрын захирал

Хүний нөөц

Ажилтнууд

Компанийн хамгийн том амжилтын үндэс нь мэргэжлийн ёс зүйтэй, даатгалын шилдэг үйлчилгээг үзүүлэгч ажилтнууд байх бөгөөд тэднийг сургаж, хөгжүүлэх, өсөж дэвших боломжийг олгох, гүйцэтгэлд суурилсан шударгаар ил тод урамшуулах, бусад нийгмийн баталгааг хангаснаар даатгуулагч, хамтран ажиллагч нарт даатгалын шилдэг үйлчилгээг үзүүлж чаддаг.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Ард даатгал компани нь 2024 оны байдлаар 100 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаа явууллаа. Хүний нөөцийн бодлогын хувьд сэтгэл ханамжтай байдлыг дэмжих, ажиллах таатай орчинд тогтвор суурьшилтай ажиллуулахыг эрхэмлэн, ажилтнуудыг хөгжүүлэх сургалтуудыг байнга зохион байгуулж хамтдаа хөгжих боломжийг олгон ажиллаа. Хүний нөөцийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Жендер:

Эмэгтэй 66%, эрэгтэй 34%

Компанид ажилласан жил:

0-1 жил ажилласан 20%

1-3 жил ажилласан 30%

3-5 жил ажилласан 8%

5-10 жил ажилласан 24%

10 дээш жил ажилласан 18%

Боловсрол:

Магистр 8%

Бакалавр 88%

Мэргэжилтэй ажилтан 2%

Бүрэн дунд 2%



Хүний нөөцийн сургалтууд:

- ✓ Салбарын ажилтнуудын "Бид Манлайлна-2024" сургалт, зөвлөгөөнийг 1 сарын 22-24-ний өдрүүдэд зохион байгууллаа. Зөвлөгөөнд компанийн 2023 оны гүйцэтгэл, дунд хугацааны зорилтууд, 2024 оны тоон, чанарын зорилтууд, 2024 оны борлуулалтын төлөвлөгөө, цаашдын ажил, түүнд салбаруудын оролцоо хэрхэн хангах талаар сургалт, мэдээллийг өгсөн.
- ✓ Ковер Хилл даатгалын брокерын урилгаар Tyser Risk Management Bangladesh компанийн мэргэжилтнүүд Үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн удирдлага сэдэвт сургалтад компанийн 10 ажилтан оролцов.

- ✓ Tyser risk management Bangladesh limited- с зохион байгуулсан "Property insurance, Underwriting and risk management" сургалтад оролцов.
- ✓ Нийслэлийн иргэдийн хэрэглээний боловсролын төвөөс зохион байгуулсан Иргэн бүрийн Эрүүл мэнд, дундаж наслалтыг дээшлүүлэх зорилготой "Эрүүл мэнд"-ийн сургалтад нийт ажиллагсад хамрагдлаа.
- ✓ Financial Education HUB байгууллагын сургагч багш нараас "Комплайнс, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэл" сэдвээр сургалтад нийтээр оролцов.
- ✓ Үндэсний давхар даатгал ХК-аас зохион байгуулсан "Даатгагчийн баталгааны даатгал болон программ ашиглалтын сургалт" ажилтнуудыг хамруулсан.
- ✓ AM Best агентлаг Санхүүгийн Зохицуулах хороо болон Үндэсний давхар даатгал ХК-тай хамтран зохион байгуулсан "Өөрийн эрсдэл ба төлбөрийн чадварын үнэлгээ, эрсдэлд суурилсан капитал, аж ахуйн нэгжийн эрсдэлийн менежмент" сургалтад ажиллагсад хамрагдсан.
- ✓ Компанийн ажилтнуудын тогтвор суурьшилтай байдал хангалттай буюу 3 жилээс дээш жил ажилласан ажилтны эзлэх хувь 50-иас дээш хувьтай байна. Ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгаагаар нийт ажилтнуудын 31 хувь нь цалин урамшуулалд, 19 хувь нь ажлын цагийн уян хатан байдалд, 15 хувь нь бүх зүйлд сэтгэл ханамжтай байдаг гэсэн үр дүнд гарсан байна.
- ✓ Компанийн ажиллагсдыг "Зайнаас ажиллах ажлын байрны зааварчилгаа"-г боловсруулан 2024 оны хавраас эхлэн мөрдөн ажиллаж эхэлсэн.
- ✓ Компанийн ирээдүйн ажиллах хүчин бэлтгэх зорилгоор "Цалинтай дадлагаар ажиллах гэрээ"-ний төслийг боловсруулан Даатгалын газар болон Нөхөн төлбөрийн газарт Санхүү эдийн засгийн их сургуулийн оюутнуудыг дадлагажуулан ажиллуулсан.
- ✓ Ажилтнуудын таатай ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх хүрээнд Оффисын засварын ажлыг хийж дуусгав.

A close-up photograph of a person's hand, wearing a dark blue sleeve, holding a row of five light-colored wooden blocks. The blocks are arranged in a slightly overlapping, diagonal line from the bottom left towards the top right. The background is dark and out of focus, with a bright light source in the upper right corner creating a soft glow.

Эрсдэлийн
УДИРДЛАГА

■ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Ард даатгал компани нь стратеги зорилтоо хэрэгжүүлэх, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд гарах эрсдэл, алдагдлыг хамгийн бага түвшинд байлгах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах зорилгоор эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг баталсан ба эрсдэлийн удирдлагын зохион байгуулалтыг дараах үндсэн хэсэгт авч үздэг.

- **Эрсдэлийг тодорхойлох** - Компанийн нэгж, алба тус бүр батлагдсан аргачлалын дагуу өөрийн үндсэн үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлж Эрсдэл хариуцсан нэгжид хүргүүлнэ.
- **Эрсдэлийг шинжлэх, үнэлэх** – Эрсдэл хариуцсан нэгж нь компанийн дотоод болон гадаад орчны эрсдэлийг шинжлэн үнэлж, эрсдэлийг бууруулах арга зам, дүгнэлтийг боловсруулан компанийн Удирдлагын Хороонд танилцуулна.
- **Эрсдэлийг хянах** - Удирдлагын Хороо нь эрсдэлийн үнэлгээг хянан нэгтгэж, Эрсдэлийн тайланг улирал бүр ТУЗ-ийн дэргэдэх холбогдох хороонд хүргүүлнэ.
- **Эрсдэлийг тайлагнах** - ТУЗ-ийн дэргэдэх хороо нь ТУЗ-ийн улирал бүрийн хуралдаанд компанийн эрсдэлийн тайланг танилцуулна.
- **Эрсдэлийг шийдвэрлэх** – ТУЗ нь Компанийн эрсдэлийн тайланг хэлэлцэж эрсдэлийг бууруулах шаардлагатай шийдвэрүүдийг гаргаж компанийн Удирдлагын хороонд үүрэг чиглэл өгнө.

2024 онд Эрсдэлийн удирдлагын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

- ✓ ТУЗ-ийн хурлуудаар Компанийн эрсдэлийн тайланг 4 удаа танилцуулж, эрсдэлийг бууруулах чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулсан.
- ✓ Үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлж сар бүр тайлагнан Удирдлагын хорооны хуралд танилцуулж, тодорхой шийдвэрүүдийг гаргаж ажилласан.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- ✓ Даатгалын бүтээгдэхүүнийг эрсдэлээр нь ангилж, эрсдэл ихтэй бүтээгдэхүүний сайжруулах арга хэмжээнүүдийг авсан.
- ✓ Жолоочийн даатгалын хууль болон жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журмын хэлэлцүүлэгт оролцож бүтээгдэхүүнийг сайжруулах талаар санал, хүсэлтийг тусгаж ажилласан.
- ✓ Эрсдэл ихтэй даатгалуудыг Давхар даатгалд хамруулах, давхар даатгалын нөхцөлүүдийг сайжруулах чиглэлд ажилласан байна.

Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он
Хохирлын харьцаа*	40%	41%	49%
Зардлын харьцаа**	59%	56%	49%
Хосолсон харьцаа	99%	97%	98%

*Цэвэр нөхөн төлбөр / Орлогод тооцсон хураамж

** Үйл ажиллагааны зардал / Орлогод тооцсон хураамж

■ ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ард даатгал компани Англи, Америк, Герман, Япон, Сингапур, Швейцар зэрэг олон улсын өндөр үнэлгээ бүхий давхар даатгалын томоохон компаниудад тогтмол даатгуулж ирсэн туршлагатай билээ.

Бид ХБНГУ-ын Аллианц компанитай стратегийн түншлэлийн хүрээнд урт хугацааны туршид хамтран ажиллаж байна. Мөн Ханновер Ри, Монголиан Ри, Свисс Ри зэрэг компаниуд нь манай байнгын хамтран ажилладаг давхар даатгагч бөгөөд бид өөрсдийн эрсдэлийн багцыг факультатив болон трити гэрээ байгуулан давхар даатгуулдаг.

Давхар даатгалын хураамж (сая төгрөг)

Давхар даатгалын гэрээ	2023 он	хувь	2024 он	хувь
Факультатив	1,528	27%	3,163	44%
Фронтинг	3,339	59%	3,150	44%
Трити	792	14%	838	12%
НИЙТ	5,660	100%	7,150	100%

Давхар даатгалын нөхөн төлбөр (сая төгрөг)

Даатгалын хэлбэр	2023 он	хувь	2024 он	хувь
Эрүүл мэнд, гэнэтийн осол	196	5%	87	9%
Хөрөнгийн даатгал	729	19%	258	28%
Малын индексжүүлсэн даатгал	320	8%	586	63%
Санхүүгийн даатгал	2,559	67%	-	-
НИЙТ	3,804	100%	931	100%

НӨХӨН ТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ард даатгал компани нь 2024 онд олгосон нөхөн төлбөрөөр салбартаа тэргүүлэгч байсан бөгөөд 2024 онд дараах ажлуудыг хэрэгжүүлж ажиллаа.

- ✓ Бид 2024 оны жилийн эцсээр 19.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг 13 мянган харилцагчид олгосон бөгөөд олгосон нөхөн төлбөрийн хэмжээ нь даатгалын салбарын 12 хувийг эзэлсэн байна.
- ✓ Бид сүүлийн 7 жил ХХБ-тай цалингийн зээлийн даатгалаар хамтран ажиллаж байгаа бөгөөд 2024 онд нийт 261 даатгуулагчид 2.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгож зээлдэгчид учирсан санхүүгийн хохирлыг барагдуулан ажилласан байна.
- ✓ Малын индексжүүлсэн даатгалаар 2024 онд Улаанбаатар хот болон 13 аймгийн 292 малчин өрхөд 122.1 сая төгрөг, Хаан банк болон Төрийн банкаар даатгуулсан малчин өрхөд 574.7 сая төгрөг нийт 696.8 сая төгрөгийн нөхөн төлбөр олгож, зудын эрсдэлд малаа алдсан малчдад учирсан санхүүгийн хохирлыг шийдвэрлэсэн байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- ✓ 2024 онд 6,490 иргэн, 6,508 байгууллага, нийт 12,988 даатгуулагчид учирсан хохирлыг даатгалын гэрээний дагуу нөхөн төлсөн байна.

Даатгалын нийт нөхөн төлбөр 2023 оноос 39 хувь, нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо 47 хувиар тус өссөн байна. Даатгалын нөхөн төлбөрийн мэдээллийг хүснэгтлэн харуулбал

	Нийт нөхөн төлбөр (сая төгрөг)			Даатгуулагчийн тоо		
	2023 он	2024 он	өөрчлөлт	2023 он	2024 он	өөрчлөлт
ГО, эмчилгээний даатгал	2,197	2,440	11%	2,899	2,193	-24%
Хөрөнгийн даатгал	1,103	497	-55%	158	215	36%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	2,608	3,861	48%	1,620	2,470	52%
Ачааны даатгал	36	67	84%	15	10	-33%
Хариуцлагын даатгал	80	279	247%	56	61	9%
Зээлийн даатгал	1,759	2,456	40%	253	266	5%
Санхүүгийн даатгал	1,706	-	-100%	1	-	100%
Жолоочийн даатгал	4,157	9,366	125%	3,804	7,782	105%
Бусад	449	697	55%	16	1	-94%
НИЙТ	14,095	19,663	39%	8,822	12,998	47%

КОМПЛАЙНСЫН ХӨТӨЛБӨР

Ард даатгал компани нь үйл ажиллагаагаа хууль тогтоомж, дүрэм журмыг баримтлан, нийцүүлж ажиллахыг чухалчилдаг ба бизнесийн үйл ажиллагаанд хамаарах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөхөд анхаарч ажилладаг.

2024 онд Комплайнсын ажлын хүрээнд үйл ажиллагаанд баримталдаг дотоод дүрэм журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах, засаглалын хяналтыг сайжруулах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- ✓ Комплайнсын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж ТҮЗ-өөр батлуулсан. Хөтөлбөрт авлига, хээл хахууль, мэргэжлийн ёс зүйг сахих, шүгэл үлээх агуулгуудыг нэмж тусгасан.
- ✓ Комплайнсын ажилтныг чадавхжуулах, мэргэшүүлэх хүрээнд холбогдох сургалтуудад байнга хамруулж сертификат авсан ба ажилтнуудад байнга сургалт явуулж ажиллаа.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- ✓ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд Мөнгө угаах, терроризмтой тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж батлуулсан.
- ✓ Комплайнсийн эрсдэлийн үнэлгээний тайланг холбогдох талуудад танилцуулж шийдвэр гаргуулсан.
- ✓ Хөдөлмөрийн дотоод журамдаа жендерийн тэгш эрх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс ангид байх, Комплайнсын асуудлуудыг нэмж тусган батлуулсан.
- ✓ Харилцагчийг таньж мэдэх асуулгын хуудсыг шинэчлэн, даатгалын үйл ажиллагаанд ашиглаж байна.





САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ
ХАРААТ БУС АУДИТОРЫН ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ

Ард Даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Аудиторын дүгнэлт

Бид Ард даатгал ХК (цаашид "Компани" гэх)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-уудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартаар шаардсан бүх тодруулгыг иж бүрэн агуулаагүй тул "Ард Даатгал" ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2025 оны 03 дугаар сарын 28-ний өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын Аудитын тухай хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК



Монгол Улс, Улаанбаатар хот
2025 оны 3 дугаар сарын 28-ны өдөр

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
Nexia Интернэйшнл-ийн албан ёсны гишүүн
Веб: www.nexia.com

КОМПАНИЙН 2024 ОНЫ АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

АРД ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИ

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	Тод	12/31/2024	(Дахин тайлагнасан*) 12/31/2023
Даатгалын орлого	6.1	40,760,110	25,807,188
Даатгалын үйлчилгээний зардал	6.2	(25,744,203)	(17,666,135)
Даатгалын үйлчилгээний үр дүн	6.3	15,015,907	8,141,053
Давхар даатгалаас хүлээн авсан нөхөн төлбөр	6.4	861,360	3,868,616
Давхар даатгалын хураамжийн төлөлт	6.5	(6,986,039)	(5,487,971)
Давхар даатгалын цэвэр үр дүн		(6,124,679)	(1,619,355)
Даатгалын үйл ажиллагааны үр дүн	6	8,891,228	6,521,698
Хорогдуулсан хөрөнгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого		3,025,274	1,907,735
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх хөрөнгийн орлого		254,909	1,237,144
Цэвэр хөрөнгө оруулалтын орлого	7	3,280,183	3,144,879
Бусад орлого	8	167,966	807,340
Бусад зардал	9	(485,601)	(772,210)
Ерөнхий ба удирдлагын зардал	10	(2,567,542)	(2,044,144)
Борлуулалт, маркетингийн зардал	11	(6,372,098)	(4,577,808)
Бусад үйл ажиллагааны зардал		-	-
Санхүүгийн зардал		(2,204)	(24,163)
Татварын өмнөх ашиг		2,911,932	3,055,592
Орлогын албан татварын зардал	12	(501,530)	221,656
Тайлант үеийн цэвэр ашиг		2,410,402	3,277,248
Бусад дэлгэрэнгүй орлого			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	27	(2,010,922)	(1,985,923)
Нийт дэлгэрэнгүй орлого		399,480	1,291,325

* Аудитлагдсан санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 17-ийн дагуу толилуулагдсан, зарим нэг дүнгийн ангилалыг сольсон ба залруулгууд хийгдсэн тул Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлантай таарахгүй болно.

КОМПАНИЙН 2024 ОНЫ АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

АРД ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИ

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	12/31/2024	(Дахин тайлагнасан*) 12/31/2023
ХӨРӨНГӨ		
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	857,984	4,226,869
Санхүүгийн хөрөнгө:	29,303,655	24,732,264
Хорогдуулсан өртгөөр бүртгэх	24,827,241	19,888,201
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх	4,476,414	4,844,063
Даатгалын гэрээний хөрөнгө	9,645,560	6,758,997
Давхар даатгалын гэрээний хөрөнгө	95,468	29,799
Авлага	1,534,399	1,071,869
Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо ба бусад хөрөнгө	1,659,928	1,636,760
Бараа материал	179,612	31,018
Үндсэн хөрөнгө	1,006,845	488,112
Биет бус хөрөнгө	4,944,616	2,913,296
Ашиглах эрхтэй хөрөнгө	64,319	178,131
Нийт хөрөнгийн дүн	49,292,386	42,067,115
ӨР ТӨЛБӨР		
Даатгалын гэрээний өр төлбөр	25,244,082	20,020,205
Давхар даатгалын гэрээний өр төлбөр	1,655,706	1,574,936
Дансны ба бусад өр төлбөр	1,560,836	884,480
Санхүүгийн түрээсийн төлбөр	70,322	317,050
Орлогын татварын өр төлбөр	189,425	228,687
Хойшлогдсон татварын өр төлбөр	335,384	182,586
Нийт өр төлбөрийн дүн	29,055,755	23,207,944
ЭЗДИЙН ӨМЧ		
Хувьцаат капитал	5,000,000	5,000,000
Нэмж төлөгдсөн капитал	3,280,854	3,280,854
Дахин үнэлгээний нэмэгдэл	(2,010,922)	(1,985,923)
Тусгай нөөц сан	641,253	641,253
Хуримтлагдсан ашиг	13,325,446	11,922,987
Нийт эздийн өмч	20,236,631	18,859,171
Нийт өр төлбөр ба эздийн өмч	49,292,386	42,067,115

* Аудитлагдсан санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 17-ийн дагуу толилуулагдсан, зарим нэг дүнгийн ангилалыг сольсон ба залруулгууд хийгдсэн тул Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлантай таарахгүй болно.

АРД ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИ
2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(Мянган төгрөгөөр)	Эздийн өмч	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Тусгай нөөц сан	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмч
2022 оны 12 сарын 31-ээрх	5,000,000	3,280,854	(267,491)	641,253	8,665,920	17,320,536
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	(20,181)	(20,181)
2023 оны 1 сарын 1-ээрх залруулсан үлдэгдэл	5,000,000	3,280,854	(267,491)	641,253	8,645,739	17,300,355
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	3,277,248	3,277,248
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	(1,718,432)	-	-	(1,718,432)
Эздийн өмчийн өөрчлөлт	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
2023 оны 12 сарын 31-ээрх	5,000,000	3,280,854	(1,985,923)	641,253	11,922,987	18,859,171
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	(257,943)	(257,943)
2024 оны 1 сарын 1-ээрх залруулсан үлдэгдэл	5,000,000	3,280,854	(1,985,923)	641,253	11,665,044	18,601,228
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	2,410,402	2,410,402
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	(24,999)	-	-	(24,999)
Эздийн өмчийн өөрчлөлт	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(750,000)	(750,000)
2024 оны 12 сарын 31-ээрх	5,000,000	3,280,854	(2,010,922)	641,253	13,325,446	20,236,631